



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/42

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Борлуулалтын цэгийн барилгын хаяг, камержуулалтын ажлын гүйцэтгэгчээр “УГТАХ ОЧИР”ХХК-ыг сонгон 15,200,000 (арван таван сая хоёр зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээний дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэж, дуусгахыг “УГТАХ ОЧИР” ХХК-ний захирал (С.Угтахбаатар)-д даалгасугай.

3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ